



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Баянзүрх дүүргийн “Орхон түшээ мөрөн” ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/012/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2026 он

Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр
Утас: 11315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
Аудитын менежер: Я.Алтанцэцэг
Утас: 11315558 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: СМД аудит ХХК-ийн
Гүйцэтгэх захирал: Д.Гэндэнпэлжээ
Утас: 99110699 Цахим хаяг: munkhtsatsral@cmdaudit.mn
Аудитор: А.Цээням
Утас: 99442140 Цахим хаяг: tseenyam1202@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	1
НЭГ. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	6
3.1 Төлбөрийн акт	6
3.2 Зөвлөмж.....	6
ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	8
4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	8
Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээлэл	8

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МӨАУМХ	Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоо
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НӨХГ	Нийслэлийн өмчийн харилцааны газар
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТББ	Төрийн бус байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМС	Эрүүл мэндийн сайд

НЭГ. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026-05-13 № 585

танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ
ДҮҮРГИЙН ОРХОН ТҮШЭЭ МӨРӨН
ӨЭМТ-ИЙН ДАРГА Э.АЛИМАА
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Баянзүрх дүүргийн Орхон түшээ мөрөн ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Орхон түшээ мөрөн ӨЭМТ нь Эрүүл мэндийн даатгалын сангаас нэг иргэнд ногдох зардлын санхүүжилтээр 408.8 сая төгрөгийн, 4 төрлийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтээр 88.1 сая төгрөгийн, шүдний үзлэгийн 7.2 сая төгрөгийн, нийт 504.2 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, эрүүл мэндийн ерөнхий газрын санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж, иргэнд чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн шинэчлэл хийсэн байна.

C:\Users\narangua\Desktop\Бичир хэргийн хураангуй тайлан\2026-05-13\20260513_0585

1426050485

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 10 зорилтын хүрээнд 33 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 2025 оны гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/47 дугаар захирамжаар 88.5 хувь, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, худалдан авах даатгалын гэрээний биелэлтийг 90.9 хувийн хэрэгжилттэй гэж үнэлсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1. ХӨРӨНГӨ	-	-
1.1 Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	82,108.71	78,771.37
1.1.2 Дансны авлага	-	-
1.1.3 Татвар, НДШ – ийн авлага	2,795,207.34	-
1.1.4 Бусад авлага	30,097,285.97	5,685,281.80
1.1.5 Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6 Бараа материал	26,076,267.56	17,886,162.60
1.1.11 Эргэлтийн хөрөнгийн дүн	59,050,869.58	23,650,215.77
1.2 Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1 Үндсэн хөрөнгө	203,483,008.03	154,933,657.81
1.2.10 Эргэлтийн бус хөрөнгийн дүн	203,483,008.03	154,933,657.81
1.3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	262,533,877.61	178,583,873.58
2. ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1 Өр төлбөр	-	-
2.1.1 Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.1 Дансны өглөг	-	-
2.1.1.3 Татварын өр	5,238,488.52	3,600,003.60
2.1.1.8 Урьдчилж орсон орлого	192,985,363.10	-
2.1.1.10 Бусад богино хугацаат өр төлбөр	26,200,800.00	2,559,893.64
2.1.1.13 Богино хугацаат өр төлбөрийн дүн	224,424,651.62	6,159,897.24
2.2 Өр төлбөрийн нийт дүн	224,424,651.62	6,159,897.24
2.3 Эздийн өмч	-	-
2.3.1 Өмч:	126,118,593.00	126,118,593.00
2.3.1.1 - төрийн	126,118,593.00	126,118,593.00
2.3.6 Эздийн өмчийн бусад хэсэг	390,000.00	390,000.00
2.3.7 Хуримтлагдсан ашиг	(88,399,367.01)	45,915,383.34
2.3.9 Эздийн өмчийн дүн	38,109,225.99	172,423,976.34
2.4 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	262,533,877.61	178,583,873.58

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1. Борлуулалтын орлого (цэвэр)	-	-
2. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-
3. Нийт ашиг (алдагдал)	-	-
4. Санхүүжилтийн орлого	494,689,911.93	504,157,491.30
5. Хүүний орлого	17,372.86	21,078.21
6. Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	192,985,546.10
8. Бусад орлого	-	5,108,046.33
9. Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10. Ерөнхий ба удирдлагын зардал	522,193,831.98	567,957,411.59
11. Санхүүгийн зардал	-	-
18. Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(27,486,547.19)	134,314,750.35
19. Орлогын татварын зардал	-	-
20. Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	(27,486,547.19)	134,314,750.35
21. Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(27,486,547.19)	134,314,750.35

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	93.00	-	643,117.46	643,210.46
2. Залруулсан үлдэгдэл	126,118,593.00	390,000.00	(60,911,082.54)	65,597,510.46
3. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(27,488,284.47)	(27,488,284.47)
8. Эхний үлдэгдэл /төгрөгөөр/	126,118,593.00	390,000.00	(88,399,367.01)	38,109,225.99
9. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
10. Залруулсан үлдэгдэл	126,118,593.00	390,000.00	(74,967,891.98)	38,109,225.99
11. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	134,314,750.35	134,314,750.35
16. Эцсийн үлдэгдэл /төгрөгөөр/	126,118,593.00	390,000.00	45,915,383.34	172,423,976.34

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1 Мөнгөн орлогын дүн	473,748,843.14	536,057,314.01
1.1.1 Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	473,748,843.14	536,057,314.01
1.2 Мөнгөн зарлагын дүн	473,787,334.43	536,060,651.35
1.2.1 Ажиллагчдад төлсөн	300,124,661.89	343,035,542.36
1.2.2 Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	38,276,235.12	49,802,060.72
1.2.3 Бараа материал худалдан авахад төлсөн	30,265,850.00	28,326,409.28
1.2.4 Ашиглалтын зардалд төлсөн	55,007,567.00	62,948,719.00
1.2.5 Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,750,000.00	1,625,900.00
1.2.7 Татварын байгууллагад төлсөн	19,478,950.00	42,968,452.00
1.2.8 Даатгалын төлбөрт төлсөн	-	54,200.00
1.2.9 Бусад мөнгөн зарлага	28,884,070.42	7,299,367.99
1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(38,491.29)	(3,337.34)
2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1 Мөнгөн орлогын дүн	-	-
2.2 Мөнгөн зарлагын дүн	-	-
3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1 Мөнгөн орлогын дүн	-	-
3.2 Мөнгөн зарлагын дүн	-	-
4. Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(38,491.29)	(3,337.34)
5. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	120,600.00	82,108.71
6. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	82,108.71	78,771.37

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 13,778.8 мянган төгрөгийн 3 зөрчил¹ илэрснээс 1,247.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 12,531.8 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн 13,778.8 мянган төгрөгийн алдаа, зөрчлөөс санхүүгийн тайлагналтай холбоотой 5,823.7 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

- Тайлант онд ажиллагсдад олгосон үр дүн, шагнал урамшууллаас 1,247.0 төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутган тооцож төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь “Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна”, 7.1.1-д “ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого”, 21.2.4-д “энэ хуулийн 15.1, 16 дугаар зүйл, 17.1.2, 17.1.3-т зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна” заалтад заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үр дүн, шагнал урамшууллаас дутуу суутгасан 1,247.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Бараа материалын данстай холбоотой асуудал:**

Илрүүлэлт-1. Тус байгууллагын нярав нь эмийн тайланг сар бүр гарган, нягтлан бодогчоор хянуулаагүй, 4,576.7 мянган төгрөгийн зарлагыг эхний 9 сарын байдлаар нэгтгэн гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын “Толилуулга”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эм эмнэлгийн хэрэгслийн зарцуулалтын тайланг сар бүр гарган, тооцог бодож, ажил гүйлгээг хуулийн хүчин төгөлдөр анхан шатны баримтад үндэслэн нягтлан бодох бүртгэлийн дэлгэрэнгүй, хураангуй бүртгэлд тусган баталгаажуулж, санхүүгийн тайланг зөв илэрхийлж, зөвлөмж өгөв.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт-2. Бараа материалын худалдан авалтын анхан шатны баримт болох цахим төлбөрийн "Е баримт"-ыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагаар шивүүлээгүй 7,955.1 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*", гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "*Нийцсэн бөгөөд зохистой байх*" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бэлтгэн нийлүүлэгчдээр цахим төлбөрийн е-баримтыг бүрэн шивүүлж гүйлгээг хийж хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг НТАГ-т 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд ажиллагсдад олгосон үр дүн, шагнал урамшууллын нийт 12,470.0 мянган төгрөгөөс ХХОАТ-ын 1,247.0 мянган төгрөгийг суутган тооцож төсөвт төвлөрүүлээгүй.	1	1,247.0	1	1,247.0	-	-		
Тус байгууллагын нярав нь эмийн тайланг сар бүр гарган, нягтлан бодогчоор хянуулаагүй, 4,576.7 мянган төгрөгийн зарлагыг эхний 9 сарын байдлаар нэгтгэн гаргасан.	1	4,576.7					1	4,576.7
Бараа материалын худалдан авалтын анхан шатны баримт болох цахим төлбөрийн "Е баримт"-ыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагаар шивүүлээгүй 7,955.1 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн.	1	7,955.1			-	-	1	7,955.1
Дүн	3	13,778.8	1	1,247.0	-	-	2	12,531.8

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээлэл

	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчлөлүй	Хязгаарлалт тай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	6	7	8	9
1	ОНӨҮГ		1			1			
	НИЙТ		1			1			



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 дугаар сарын 13

№ 128/151990235

Улаанбаатар хот

МНТ-2026/012/НА-СТА-ОНӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Баянзүрх дүүргийн Орхон Түшээ Мөрөн Өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд ажиллагсдад олгосон үр дүн, шагнал урамшууллаас 1,247,000.0 (нэг сая хоёр зуун дөчин долоон мянга) төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутган тооцож төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна”, 7.1.1-д “ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого”, 21.2.4-д “энэ хуулийн 15.1, 16 дугаар зүйл, 17.1.2, 17.1.3-т зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.4-д “Төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй” заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Үр дүн, шагнал урамшууллаас дутуу суутгасан 1,247,000.0 (нэг сая хоёр зуун дөчин долоон мянган) төгрөгийг Нийслэлийн Баянзүрх дүүргийн Орхон Түшээ Мөрөн Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга (Э.Алимаа), нягтлан бодогч (Д.Нарантуяа) нараар төлүүлж, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь НТАГ.хүү торгуулийн орлогын данс MN440090100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг Нийслэлийн Баянзүрх дүүргийн Орхон Түшээ Мөрөн Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга (Э.Алимаа), нягтлан бодогч (Д.Нарантуяа) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР

“СМД АУДИТ” ХХК-ИЙН АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
А.ЦЭЭНЯМ

¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426110181